

Товч мэдээ, ажиглалт

**ДЭМБ томуугийн вакцины найрлагын тухай зөвлөмжөө нийтлүүлэв**

ДЭМБ жил бүрийн 2 дугаар сард томуугийн ирэх улиралд Дэлхий бөмбөрцгийн хойд хагаст хэрэглэх вакцины найрлагын тухай зөвлөмж гаргадаг билээ. 2011-2012 оны томуугийн улиралд буюу ирэх 9 дүгээр сараас хэрэглэвэл зүйтэй гэж үзэж буй гурван цэнт вакцины найрлагыг ДЭМБ энэ оны 2 дугаар сарын 17-нд зарлалаа.

ДЭМБ-тай хамтран ажилладаг Томуугийн Үндэсний Төвүүдээс авч байгаа 7 хоног тутмын мэдээ, Лавлагаа төвүүдийнхээ судалгаан дээр үндэслэн томуугийн ирэх улиралд Дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын орнуудад энэ жилийн зөвлөмж болгосон найрлагатай вакцинаа үргэлжлүүлэн хэрэглэх нь зүйтэй гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, томуугийн 2011-2012 оны улиралд хэрэглэх вакцин нь:

**П.Нямдаваа**

A/California/7/2009(H1N1)-төст,  
A/Perth/16/2009(H3N2)-төст,  
B/Brisbane/60/2008-төст омог агуулсан гурван цэнт найрлагатай байх нь зүйтэй гэж ДЭМБ үзсэн байна.



**Японы Сендай хот дахь Тохоку Их Сургуулийн судлаачид ирж ажиллалаа**

2011 оны 1 дүгээр сарын 24-нөөс 31-ний өдрүүдэд Японы Сендай хотын Тохоку Их Сургуулийн профессор Хитоши Ошитани, доктор Сузуки Акира, магистрант Тохма Кентаро нар МАУА-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу ирж, ХӨСҮТ-ийн томуугийн лабораторийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллав. Энэ хугацаанд аденовирүсийн гестоны уургийн нуклеотидийн дарааллыг тогтоож, генотипийг тодорхойлох шинжилгээг Монгол улсад илрүүлсэн аденовирүсийн арваад омог дээр туршиж, уг аргыг манай лабораторид нэвтрүүлээ.

**Ц.Наранзул  
Б.Ганцоож**



**Томуугийн цартахлын А(H1N1) халдварын эсрэг вакцин, тариур, аюулгүй хайрцгийн зарцуулалт**

Томуугийн цартахлын А(H1N1) вирүсийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай Эрүүл Мэндийн сайдын 2010 оны 375 тоот тушаалын дагуу аймаг, нийслэл, 3-р шатлалын 3 эмнэлгээс хуваарилсан вакцин, тариур, аюулгүй хайрцгийн

зарцуулалтын явцын тайланг авч нэгтгэлээ.

Улсын хэмжээнд нийт 300 000 хүн тун вакцины 159 400 (53.1%)-ийг 21 аймагт, 96 750 (32.2%)-ийг нийслэлийн 9 дүүрэгт, 5 960 (14.7%)-ийг 3-р шатлалын 3 (Төмөр замын эмнэлэг, клиникийн 2-р эмнэлэг, Зэвсэгт хүчний жанжин штабын эмнэлэг) эмнэлэгт тус тус хуваарилан хүргүүлсэн.

2011 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар хүргэгдсэн вакцинаас аймгуудад 71 975 (45.1%), нийслэлд 24 968 (27.3%) хүн дархлаажуулалтанд хамрагдсан байна.

Вакцинжуулалтын хамралт Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Баянхонгорт 100%, Ховд, Дорноговьт 80-87%, Дундговь, Төв аймагт 68%-70%, Сүхбаатар, Увс, Архангай, Орхон, Баян-Өлгий, Дархан-Уул, Сэлэнгэ, Говьсүмбэр, Хэнтий аймгуудад 30%-41%-тай байна.

Өвөрхангай, Хөвсгөл, Завхан аймгууд сумдуудаас вакцинжуулалтын хамралтын мэдээг аваагүй тул нэгтгэгдэх боломжгүй байна.

Нийслэлийн хувьд вакцинжуулалтын хамралт Чингэлтэй дүүрэгт 70,4%, Сонгинохайрхан, Баянзүрх, Багахангай дүүрэгт 24% - 36%, Баянгол, Налайх, Багануур дүүргүүдэд 1% - 18%-тай байна.

3-р шатлалын 3 эмнэлгээс төмөр замын эмнэлэг, клиникийн 2-р эмнэлэг вакцинжуулалтыг 100% хийж дууссан байна.

**Д.Оюунгэрэл**



**Шинэ омгийн хемагглютининий гений нуклеотидын дарааллыг тодорхойлж GEN BANK-нд бүртгүүлэв**

Томуугийн үндэсний төвийн вирүс судлаачид 2011 оны нэгдүгээр сарын 11-нд авсан сорьцонд илрүүлсэн томуугийн А(H1N1) цартахлын вирүсийн А/Улаанбаатар/190/2011 омгийн хемагглютининий генийн бүрэн дарааллыг тогтоож, нэгдүгээр сарын 19-нд GenBank-нд CY080420 дугаартай бүртгүүлсэн <http://www.ncbi.nlm.nih.gov/nucleotide/319659310> нь энэ онд бүртгүүлсэн хамгийн анхны томуугийн вирүсийн секвэнс боллоо хэмээн манай судлаачдад баяр хүргэсэн мэдээг “Рекомбиномикс” хэмээх судлаагааны вэб-сайт нэгдүгээр сарын 20-нд нийтлэжээ [http://www.recombinomics.com/News/01201101/H1N1\\_Mongolia\\_2011.html](http://www.recombinomics.com/News/01201101/H1N1_Mongolia_2011.html) .

А/Улаанбаатар/190/2011 омгийн хемагглютинин нь 2009 оны цартахлын вирүсийн эх омгийн нэг болох А/California/07/2009 (H1N1) омгийнхоос 2 байрлалд, тухайлбал 188 дугаар байрлалд серин нь треонинаар (S188T), 208 дугаар байрлалд “Х” нь глутаминаар (X208Q) тус тус солигдсон мутацтай байв (Зураг). Үүнээс S188T мутац нь АНУ-д 2010 оны 10 дугаар

сараас илэрч эхэлсэн бөгөөд Иран, Их Британи, ОХУ-д 2010 оны 12 дугаар сараас илэрч эхэлсэн, цартахлын вирусийн шинээр тархах хандлагатай шинэ дэд бүлэг(sub-clade)-г хамаарч байна гэж “Рекомбиномикс” вэб-сайт мэдээлсэн байна.

П.Нямдаваа

◆ ◆ ◆  
**Томуугийн А(Н1N1)2009 цартахлын  
 вирусийн орчил зогсоогүй байна**

Томуугийн А(Н1N1)2009 цартахлын вирусийн орчил Дэлхий дахинд зогсоогүй байгаа (Зураг 1) тул манай оронд ч дахин тархах нөхцөл арилаагүй байна.

ТҮТ-д энэ оны нэгдүгээр сард Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нэгэн тандалтын цэгээс ирүүлсэн 2 настай хүүхдийн хамар-залгиурын сорьцонд А(Н1N1)2009 цартахлын вирус илэрсэн нь үүний баталгаа боллоо. Энэ өвчтөний эмнэлзүйн илрэл нь ТТӨ-ний бусад илрэлээс ялгаагүй, хөнгөвтөр, гэрээр эмчлүүлж байгаа бөгөөд голомтын эпидемиологийн шинжилгээ үргэлжлэн хийж байна.

Цартахлын вирусийн цаашдын тархалт нь энэ вирусийн эсрэг манай хүн амын дархлалын түвшингээс хамаарах бөгөөд уг вирусийн эсрэг вакциныг өргөн хэрэглэсэн, хүн амын дархлалын түвшин ерөнхийдөө хангалттай байгаа судалгаа гарсан болохоор шинэ мутаци үүсээгүй бол өвчлөл зөвхөн вакцинжуулалтанд хамрагдаагүй хүмүүсийг хамран тархах болно. Судалгаа үргэлжилж байна.

П.Нямдаваа

◆ ◆ ◆  
**Талархал**

Манай вэб-сайт 2008 оны нэгдүгээр сарын 8-нд анхны мэдээгээ нийтийн хүртээл болгосноос хойш бүтэн 2 жил улиран одож, энэ өдрүүдэд гуравдахь оныхоо түүхийг эхлэж байна.

2011 оны нэгдүгээр сарын 5-аар тасалбар болгон тооцож үзэхэд өнгөрсөн хугацаанд манай вэб-сайтын монгол хувилбарт нийт 556 материал тавигдсаныг 132 856 удаа үзсэн, өөрөөр хэлбэл манай нэг материалыг дунджаар 239 удаа үзсэн статистик гарч байна. Вэб-сайтын тоолуурын заалтаар үзвэл вэб-сайтын монгол хувилбарыг өдөр бүр 250-300 удаа, 7 хоног бүр 1700-2100 удаа үздэг болсон байна.

Манай вэб-сайтын хамгийн тогтмол булан нь “Томуугийн тандалтын мэдээ” бөгөөд томуугийн энэ улиралын 7 хоног тутмын мэдээг дунджаар 67 удаа үзэж байгаа бол, 2009 оны 43 дахь 7 хоногийн мэдээг хамгийн олон буюу 965 удаа, 2010 оны 45 дахь 7 хоногийн мэдээг хамгийн цөөн буюу 29 удаа үзжээ.

Гэхдээ монгол хувилбарыг үзэж ашиглагчдад хамгийн сонирхолтой, хэрэгтэй мэдээллүүд нь Улсын онцгой комиссын 2009 оны 10 дугаар сарын 13-ны 5 дугаар тогтоол (2612 удаа үзсэн), Монгол улсын

ерөнхий сайдын 2009 оны 11 дүгээр сарын 2-ны 104 дүгээр тогтоол (2506 удаа үзсэн), Эрүүл мэндийн сайдын 2009 оны 10 дугаар сарын 6-ны 323 дугаар тушаал (2363 удаа үзсэн), Иргэдэд эрүүл мэндийн зөвлөлгөө өгөх утасны жагсаалт (2173 удаа үзсэн) зэрэг нийтлэг лавлагаа материалууд байжээ. Өөрөөр хэлбэл манай вэб-сайтын монгол хувилбарыг зонхилон ашиглагсад бол тодорхой зорилготой, илүү прагматик хүмүүс байсан гэж хэлж болохоор байна. Энэ ч бидний тавьсан гол зорилт мөн. Бид вэб-сайтынхаа ашиглалтын статистикийг улам гүнзгийрүүлэн судлаж, вэб-сайтаа аль болох олон хүнд хэрэгтэй, ашигтай вэб-сайт байлгахын төлөө ажиллах болно.

Манай вэб-сайттай зохиогчоор болон ашиглагчаар хамтран ажилласан хүн болгонд энэхүү завшааныг ашиглан талархсанаа илэрхийлж, хойшид ч хамтран ажиллахыг урихын хамт, энэхүү вэб-сайтын агуулга, дизайныг сайжруулах талаар саналаа харамгүй хуваалцахыг хүсэе.

П.Нямдаваа, Б.Ганцоож

◆ ◆ ◆  
**Ангаах ухааны доктор О.Баатархүү Ази  
 номхон далайн орнуудын Элэг Судлалын  
 холбооны нэрэмжит шагнал хүртлээ**

Монголын Элэгний Эмгэг Судлалын Холбооны дэд ерөнхийлөгч, ЭМШУИС-ийн Халдварт өвчин судлалын тэнхмийн орлогч эрхлэгч АУ-ны доктор О.Баатархүү, ЭМШУИС-ийн Халдварт өвчин судлалын тэнхмийн ахлах багш, АУ-ны доктор Н.Хоролсүрэн, Нийгмийн Эрүүл мэндийн хүрээлэнгийн Молекул биологийн лабораторийн эрхлэгч, биологийн ухааны доктор Сайнчимэг нар Япон улсад зохиогдсон Ази Номхон Далайн Орнуудын Элэг Судлалын Холбооны 7-р бага хуралд Монгол улсыг төлөөлөн амжилттай оролцоод ирлээ.

Тус хуралд Ази номхон далайн 20 гаруй орнуудын 400 орчим эмч, эрдэмтэн, судлаач төлөөлөгчид оролцжээ. Энэ хуралд оролцсон ЭМШУИС-ийн багш, АУ-ны доктор О.Баатархүү Монгол улс дахь гепатитын С вирусийн халдварын талаар зочин профессороор уригдан лекц уншиж, мөн ханан илтгэлийн хуралдааныг даргаллаа.

АУ-ны доктор О.Баатархүү Монголын анагаах ухааны салбарыг бүсийн түвшинд үнэлсэн нэр хүндтэй шагналын эзэн боллоо. Тэрээр Ази номхон далайн орнуудын Элэг судлалын холбооны энэхүү нэр хүндтэй шагналыг “Монгол улсын хүн амын дундах С гепатитын генотипийн судалгаа” сэдэвт илтгэлээрээ хүртэж, Монгол эрдэмтний бүтээлийг өндрөөр үнэлүүлээ.

Л.Энхбаатар